



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 81946

Улаанбаатар хот

Тэтгэмж олгох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх заалт, Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн 2022 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт гаалийн улсын байцаагчаар ажиллаж байгаад нас барсан Догсомын Дашдондовын эхнэр Ш.Даваацэцэгт 10 008 996 /Арван сая найман мянга есөн зуун ерэн зургаан/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосугай.

2. Тэтгэмжид зарцуулах 10 008 996 /Арван сая найман мянга есөн зуун ерэн зургаан/ төгрөгийг зохих журмын дагуу гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 3405